

Эх, олон хvvхэдтэй орх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулиар дараах тэтгэмжvvдийг олгохоор зохицуулсан. Үvнд:
Жирэмсний таван сартайгаас эхлэн хvvхэд торvvлэх хvртэлх хугацаанд эх сар бvр тэтгэмж авах эрхтэй.
Торvvлсэн 0-3 хvртэлх насны хvvхдээ асарч байгаа эх сар бvр хvvхэд асарсны тэтгэмж авах эрхтэй.
Доров хvртэлх насны ихэр хvvхэд торvvлсэн эх нэг удаа тэтгэмж авах эрхтэй.
0-18 хvртэлх насны гурав болон тvvнээс дээш хvvхэдтэй орх толгойлсон эх, эцэг улирал бvр тэтгэмж авах эрхтэй.
Иргэн сум, хорооны нийгмийн ажилтанд хандан тэтгэмж авах хvсэлт гаргахдаа доор дурдсан баримт бичгийг бvрдvvлж огно.

**Жирэмсэн эхийн тэтгэмжид хамрагдах иргэн:**
оргодол;
1 хувь зураг;
иргэний vнэмлэх, хуулбарын хамт;
баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;
жирэмсэн vедээ эмнэлгийн хяналтад орсон тухай орх, сум, тосгоны эрvvл мэндийн товийн

эмчийн тодорхойлолт.
Жирэмсэн эхийн тэтгэмж авч байсан иргэн хүүхэд төрөнгүүт 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж авах хүсэлтээ сум, хорооны нийгмийн ажилтанд гаргана.

**0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид хамрагдах иргэн:**
өргөдөл;
1 хувь зураг;
иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
хүүхэд эсэн мэнд бойжиж байгаа тухай өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийн тодорхойлолт;
хүүхдийн төрсний гэрчилгээ, хуулбарын хамт;
Хөдөлмөрийн тухай хуулийн 106.1-д заасны дагуу хүүхэд асрах чөлөөтэй байгаа бол чөлөө олгосон тухай ажил олгогчийн тушаал, хуулбарын хамт;
баг, хорооны Засаг даргын тодорхойлолт

**Ихэр хүүхдийн тэтгэмжид хамрагдах иргэн:**
өргөдөл;
иргэний үнэмлэх хуулбарын хамт, гадаадад оршин суугаа иргэний хувьд иргэний үнэмлэх, эсхүл нотариатаар батлуулсан хуулбар;
хүүхдүүдийн төрсний гэрчилгээ, хуулбарын хамт;
ихэр хүүхэд нь эсэн мэнд бойжиж байгаа тухай өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийн тодорхойлолт;
баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;
гадаадад оршин суугаа иргэний хувьд тухайн газрын эмч, эмнэлгийн байгууллагын тодорхойлолт, Монгол улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тодорхойлолт.

**Гурав болон түүнээс дээш хүүхэд төрүүлсэн өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид хамрагдах иргэн:**
**өргөдөл;**
1 хувь зураг;
нас барсан эхнэр, эсхүл нөхрийн нас барсны гэрчилгээ, хуулбарын хамт;
баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;
хүүхдүүдийн төрсний гэрчилгээ, хуулбарын хамт /16 насанд хүрсэн бол иргэний үнэмлэх, хуулбарын хамт/;
нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.8-д заасан өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох талаар сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлөөс гаргасан шийдвэр.

ТЭТГЭМЖИЙГ ХҮСЭЛТ ГАРГАСАН САРААС ЭХЛЭН ОЛГОНО.

ТЭТГЭМЖИЙГ НОХОН ОЛГОХГҮЙ.

САР БҮР ОЛГОХ ТЭТГЭМЖИЙГ ТУХАЙН САРЫН 20-НООС ХОЙШ, УЛИРАЛД ОЛГОХ ТЭТГЭМЖИЙГ ТУХАЙН УЛИРЛЫН СҮҮЛИЙН САРЫН 20-НООС ХОЙШ ТУС ТУС ОЛГОНО.